



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 03 ДУГААР САРЫН 23-НЫ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА

2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-3
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	4-14

- 1. Женев хотноо 1958 онд батлагдсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн/*
- 2. Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг зөвшилцөх /Засгийн газар 2023.01.16-ны өдөр ирүүлсэн/*

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 03 дугаар сарын 23-ны өдөр
/Пүрэв гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Б.Энх-Амгалан ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 58 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Э.Бат-Амгалан, Х.Баделхан, Ц.Сэргэлэн, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Б.Баттөмөр;

Эмнэлгийн чөлөөтэй: Т.Аюурсайхан, Б.Бат-Эрдэнэ, Д.Бат-Эрдэнэ.

Нэг.Женев хотноо 1958 онд батлагдсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Тээвэр зохион байгуулалтын хэлтсийн дарга Э.Мөнхнасан, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ц.Нэргүйбаатар, мөн газрын шинжээч Ц.Баяржаргал, мөн яамны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын ажлын албаны мэргэжилтэн А.Энхболд, “Автотээврийн үндэстний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Гүрсоронзон, мөн газрын Судалгаа, хөгжил чанарын удирдлагын төвийн дарга Н.Зориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Н.Мөнхзэсэм, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Хуулийн төслийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Б.Энх-Амгалан, Н.Энхболд нарын тавьсан асуултад Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд нар хариулж, тайлбар хийв.

Б.Энх-Амгалан: Женев хотноо 1958 онд батлагдсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын уялдуулан зохицуулсан техникийн дүрмийг хэрэглэх болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 13 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг зөвшилцөх /Засгийн газар 2023.01.16-ны өдөр ирүүлсэн/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, мөн газрын шинжээч Ж.Нарантуяа, Боловсролын зээлийн сангийн захирал Ж.Ариунболд, судлаач Д.Баяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ж.Чимгээ, референт Б.Гандиймаа нар байлцав.

Зөвшилцөх тухай асуудлыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Б.Энх-Амгалан: Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг зөвшилцөх тухай асуудлыг зөвшөөрч гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн саналаар санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 5
Бүгд: 11
54.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлэхээр тогтов.

Уг асуудлыг 13 цаг 27 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 30 минут үргэлжилж, 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр 13 цаг 28 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХ-АМГАЛАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2023 оны 03 дугаар сарын 23-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
12 цаг 58 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Б.Энх-Амгалан: Эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Байнгын хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг Та бүхэнд танилцуулъя.

Б.Энх-Амгалан ирсэн, Г.Амартүвшин гишүүн ирсэн, П.Анужин гишүүн ирсэн, Т.Аюурсайхан гишүүн өвчтэй. Э.Бат-Амгалан гишүүн гадаадад томилолттой. Б.Баттөмөр гишүүн ирсэн байна. Х.Баделхан гишүүн орон нутагт томилолттой. С.Батболд гишүүн орж ирж байна. Б.Бат-Эрдэнэ гишүүн ирсэн, Д.Бат-Эрдэнэ гишүүн өвчтэй. Х.Булгантуяа гишүүн ирсэн, Д.Ганбат гишүүн ирсэн, Т.Доржханд гишүүн ирсэн, Б.Дэлгэрсайхан гишүүн ирсэн, Н.Наранбаатар гишүүн ирсэн, Ц.Сэргэлэн гишүүн гадаадад томилолттой,

Д.Цогтбаатар гишүүн гадаадад томилолттой, Н.Энхболд гишүүн ирсэн байна.

Ирцийг танилцуулж дууслаа. Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. Женев хотноо 1958 онд батлагдсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл.

Засгийн газар 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн. Хэлэлцэх.

Хоёр. Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц. Зөвшилцөх. Засгийн газар 2023 оны 01 сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн.

Ийм хоёр асуудал хэлэлцэхээр байна.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор саналтай гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа орьё.

Нэг.Женев хотноо 1958 онд батлагдсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн/

Ажлын хэсгийг танилцуулъя.
Ажлын хэсэг байраа эзлээрэй.

Ажлын хэсэг. Сандагийн Бямбацогт Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд, Сандагдоржийн Батболд Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Энхтайваны Мөнхнасан тус яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Тээвэр зохион байгуулалтын хэлтсийн дарга, Цэвэгжавын Нэргүйбаатар тус яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч, Цэвээнэмжилын Баяржаргал тус яамны Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч, Анжимын Энхболд тус яамны Замын хөдөлгөөний аюулгүй байдлын ажлын албаны мэргэжилтэн, Буянтогтохын Гүрсоронзон “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал, Норлоогийн Зориг “Автотээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын Судалгаа, хөгжил чанарын удирдлагын төвийн дарга.

Хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцууллаа.

Хуулийн төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. С.Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүдийнхээ өдрийн амгаланг айлтгая.

Монгол Улс 1993 оноос эхлэн авто тээврийн гадаад харилцааг өргөжүүлэн өнөөдрийн байдлаар олон улсын 7 гэрээг соёрхон баталж, Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 12 улстай байгуулан олон улсын тээвэрлэлтийн үйл ажиллагааг явуулж байгаа.

Сүүлийн жилүүдэд тус яамны зүгээс олон улсын тээвэрлэлтийн эрх зүйн орчныг сайжруулах, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, авто тээврийн салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон улсад мөрдөгдөж буй эрх зүйн хэм хэмжээг хүлээн зөвшөөрөх, тээвэрчдийнхээ эрх ашгийг хамгаалахын тулд олон улсын тээврийн гэрээ хэлэлцээрт нэгдэн орох асуудалд ихээхэн анхаарал хандуулан ажиллаж байна.

Энэхүү ажлын хүрээнд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын тээвэрлэлтийн гэрээ хэлэлцээрийн нэг болох Женев хотноо 1958 онд байгуулагдсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид Нэгдсэн Үндэстний Байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан

хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-г нэгдэхээр хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулсныг Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн дэмжээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тухай Засгийн газрын хуралдааны 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 61 дүгээр тэмдэглэл гарсан.

Монгол Улсын Засгийн газраас хуулийн төслийг 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Уг хэлэлцээрт нэгдэн орсноор тээврийн хэрэгсэл, түүний эд ангийн үйлдвэрлэл болон ашиглалт аюулгүй байдлын эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлнэ.

Тээврийн хэрэгсэл түүний эд ангийг олон улсад мөрдөж буй хийцийн аюулгүй байдлын болон ашиглалтын техникийн дүрмүүдийн дагуу үйлдвэрлэж, улмаар экспортлох боломж бүрдэнэ.

Монгол Улсад үйлдвэрлэсэн тээврийн хэрэгсэл, түүний эд ангийн хэлэлцээрийг хэлэлцэн тохирч талууд ажиглагч болон зөвлөх гишүүнчлэлийн орнууд бүрэн хүлээн зөвшөөрнө.

Бусад улс оронд үйлдвэрлэсэн тээврийн хэрэгсэл, эд ангийг өөрийн улсад ашиглах нөхцөлийг хөнгөвчлөх боломж бүрдэнэ.

Бусад улс оронд үйлдвэрлэсэн тээврийн хэрэгсэл эд ангид хяналт тавих, тэдгээр нь техникийн дүрэмд заагдсан шаардлагад нийцээгүй бол, доголдол гэмтэл гарсан бол, мөн үйлдвэрлэгчийн мэдүүлсэн техникийн үзүүлэлт тохирохгүй бол энэ тухайгаа бүрэн эрхийн дагуу тогтоох, мэдэгдэх, мэдэгдлээ хамгаалах, өөрийгөө

гэрчилгээжүүлэх чадамжтай байгууллагыг томилон ажиллуулна.

Иймээс Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-д заасны дагуу “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэр гэж өгнө үү.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: С.Бямбацогт сайдад баярлалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү. Г.Амартүвшин гишүүн асуултаа асууя. Дараа нь би асуултаа асууна. Г.Амартүвшин гишүүний микрофоныг өгье.

Г.Амартүвшин: Баярлалаа. Сайдын танилцуулгыг сонслоо. Материалтай бас танилцлаа.

Ер нь сүүлийн үед ер нь сошиалаар ч гэсэн нэлээн яваад байна. Гадаадаас импортоор орж ирж байгаа хуучин машинуудыг сэлбэг хэлбэрээр оруулж ирээд. Өөрөөр хэлбэл тэр гадаадаа осолд орсон ч юм уу, гэмтэл авсан тийм машины сэлбэгийг оруулж ирээд эндээ угсраад тэгээд ямар нэгэн осолд ороогүй юм шиг. Зар тавигдаад тэр нь зарагдаад.

Тэгээд мэдээжийн хэрэг энэ бол замын хөдөлгөөний аюулгүй байдал болон бусдын амь насанд бас нэлээн том эрсдэл учруулж байгаа ийм тохиолдлууд нэлээн гарч байгаа гэж ойлгоод байгаа. Энэ конвенцыг бид өнөөдөр баталснаар энэ нөхцөл байдал өөрчлөгдөх үү? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, машин оруулж ирээд стандарт бус тоноглол, хэрэгсэл машиндаа суурилуулж. Одоо уралдааных ч байдаг юм уу. Тийм ээ. Тийм байдлаар машиныг өөрчилж байгаа бас тохиолдол нэлээн гардаг. Энэ дээр Тээврийн цагдаагийн албаныхан ч гэсэн шалгалт хийж үе үе арга хэмжээ авдаг боловч үүнийг бид таслан зогсоож чадахгүй байгаа гэж ойлгож байгаа.

Гуравдугаарт, бүгдээрээ л машинтай. Манай иргэд бараг дийлэнх л хувийн машин унаатай. Хулхи буюу хуурамч, албан бус сэлбэг орж ирж, тэрийг хямд болохоор нь ингээд хэрэглэдэг. Тэр маань бас тодорхой хэмжээгээр осол аваар гарахад нөлөөлдөг, хүн хүний амь нас эрсдэл учруулдаг ийм тохиолдлууд байгаа.

Тэгэхээр энэ конвенц чинь бас тэрийг хамгаалах уу, үгүй юу? Энэ талаар тодорхой хариулт өгөөч. Баярлалаа.

Б.Энх-Амгалан: Г.Амартүвшин гишүүний асуултад С.Бямбацогт сайд хариулъя. С.Бямбацогт сайдын микрофоныг өгье.

С.Бямбацогт: Г.Амартүвшин гишүүн маш чухал асуудлуудыг хөндлөө.

Яг таны ярьж байгаа саяын хөндөж байгаа асуудлууд энэ конвенцод нэгдэн орсноор тодорхой хэмжээнд зохицуулагдах юм.

Өөрөөр хэлэх юм бол одоо эвдэрсэн, гэмтсэн машинуудыг сэлбэг байдлаар оруулж ирчхээд Монголд угсардаг. Мөн он засаж оруулж ирдэг. Дээрээс нь арлын дугаар засаж оруулж ирдэг. Гадаадад аваар осолд орчихсон. Тийм ээ. Эвдэрчихсэн машинуудыг бас оруулж ирдэг иймэрхүү асуудал нэлээн байгаад байгаа юм.

Энэ конвенцод нэгдээд орчих юм бол үндсэндээ энэ асуудал цэгцлэгдэнэ. Нэг талаасаа.

Нөгөө талаасаа чанаргүй, стандартын шаардлага хангаагүй хуурамч сэлбэг, материал оруулж ирэх асуудал бас нэг тодорхой түвшинд шийдэгдэнэ.

Ийм байдлаар одоо бид нар бас анхаарч шийдэх ёстой. Үүнийг одоо энэ конвенцод нэгдэн орсноор үндсэндээ харилцан олон улсын стандарт, норм дүрэм, стандарт шаардлага хангасан ийм сэлбэг хэрэгсэл, автомашин, эдгээрийг харилцан оруулж гаргах ийм бололцоо боломж бүрдэх юм. Харилцан мэдээллээ солилцоод харилцан уялдаатай ажлаа уялдуулж ажиллах ийм том боломж бүрдэнэ.

Мөн өөрийн чинь ярьж байгаа тэр Монголд одоо юу гэдэг юм стандарт бусаар өөрсдөө машин тэрэг, тоног төхөөрөмж үйлдвэрлэдэг, ашигладаг энэ байдал бол бас жоохон хавтгайрч байгаа. Үүнийг бид анхаарах ёстой. Тэгээд энэ дээр манай ямар бодлого барьж байгаа талаар С.Батболд дарга нэмээд хариулчих уу. С.Батболд дарга хариулчихъя.

Б.Энх-Амгалан: Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд дарга нэмж хариулъя.

С.Батболд: Г.Амартүвшин гишүүний асуултад хариулъя. Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд.

Ер нь энэ конвенцод нэгдэн орсноор үр ашгийн талаар сайд хариуллаа. Жишээ нь, Гаалийн ерөнхий газраас хийсэн судалгаагаар 2018 онд 497, 2019 онд 1011, 2020 онд 641 гээд ер нь Монголд ашиглах боломжгүй ийм эвдрэлтэй машинууд орж ирсэн байгаа.

Энэ машинууд орж ирээд саяын таны хэлж байгаа яг сэлбэг гэдэг нэрээр орж ирсэн машиныг угсраад машинд номер авах боломжгүй байгаа. Харин саяын эвдэрхий машинууд оруулж ирээд дээр нь сэлбэж засаад. Ялангуяа манайд Вьетнам засвар гээд. Энэ бол бүр импортоор орж ирсэн номергүй машиныг сайхан засаж гялгар болгодог ийм үйлчилгээ үзүүлээд байгаа юм.

Ингэж засаад бид бүгдэд шинэ машин гэж зарж байгаа. Энэ талаар бид бодлогын хүрээнд юу хийж байна вэ гэхээр Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд тухайн оронд ашиглахыг хориглосон ийм тээврийн хэрэгслийг импортлохыг хориглосон байгаа.

Мөн бид тээврийн хэрэгслийн бүртгэлийн журамдаа хуучин машин тухайн оронд ашиглагдаж байсан бол ашиглалтын түүхийг нь дагалдуулж оруулж ирэхээр ийм зохицуулалт хийчихсэн байж байгаа байна.

Гэх мэтчилэн олон зохицуулалтууд байгаа боловч тодорхой байгууллагуудаас биднийг ийм хориг, саад тавьж болохгүй гэдэг иймэрхүү шаардлагаар бид дүрэм журмаа одоогоор

мөрдөж чадахгүй явж байгаа юмнууд байгаа.

Ялангуяа хуулийн байгууллагуудаас Та нар ийм хориг саад тавьж болохгүй гэдэг асуудлууд байгаа. Мөн Авто тээврийн тухай хууль бид өргөн барьчихсан. Энэ хууль дээр тодорхой шаардлагуудыг тавиад, ийм ийм эвдрэл, гэмтэлтэй тээврийн хэрэгслүүдийг импортоор оруулж ирэхгүй ээ, бүртгэж авахгүй ээ гэсэн ийм зохицуулалтуудыг өргөн барьсан хуулийн төсөлд бас тусгачихсан явж байгаа.

Б.Энх-Амгалан: Г.Амартүвшин гишүүн тодруулж асууя.

Г.Амартүвшин: Ер нь импортоор гаднаас орж ирж байгаа машинуудын түүх аягүй чухал. Америкт “карфаксинк” /CARFAX.Inc/ гэж үйлчилгээ байдаг. Арлын дугаараар нь тухайн машины үйлдвэрлэсэн оноос хойш түүхийг нь харж болдог. Хэдэн эзэмшигчтэй байсан, осол аварга орж байсан эсэх гээд бүх юм нь гарч ирдэг болохоор түүн дээр ямар нэгэн эргэлзээ гардаггүй.

Тэгэхээр манайх нэгдсэн нэг тийм системтэй болмоор байх юм. Байдаг гэж сонссон. Гэхдээ иргэд юм уу, машин оруулж ирдэг нөхдүүд мэддэг ч юм уу, үгүй ч юм уу. Ойлгомжгүй байгаа юм.

Хоёрдугаарт, С.Бямбацогт сайд аа, буруу талдаа рултэй машины асуудлыг яаж шийдэх гэж байна аа? Эцсийн эцэст энэ чинь бас стандарт бус.

Манай хууль журамд нийцэхгүй, стандарт бус хэрэглээ шүү дээ. Үүнийг ер нь тэгээд яаж шийдье гэсэн бодолтой байгаа вэ?

Б.Энх-Амгалан: С.Бямбацогт сайд асуултад хариулъя.

С.Бямбацогт: Буруу талдаа рультэй машин бол үнэхээр толгойны өвчин болж байгаа.

Нэлээд олон жилийн өмнөөс оруулаад эхэлчихсэн. Өнөөдөр үндсэндээ иргэдийн дийлэнх хэрэглээ болчихсон. Үүнийг хориглохоор ард иргэдийн амьдрал хэцүү, санхүү эдийн хүнд үед иргэдэд тодорхой хэмжээний дарамт, хүндрэл учирна гээд асуудлыг шийдэж чаддаггүй ийм л байдалтай байж байгаа.

2019 онд Авто тээврийн тухай хуулийг Улсын Их Хурал өргөн барьсан. Энэ хуульд буруу талдаа рультэй машины асуудлыг шийдэхээр тодорхой зохицуулалтууд орж ирсэн байгаа. Гэтэл энэ хуулиа баталж гаргахаас бид ингээд л баталж чадахгүй үндсэндээ одоо дөрөв, таван жилийн нүүр үзэж байгаа.

Тийм болохоор одоо үндсэндээ буруу талдаа рультэй машины асуудлыг шийдэх болбол Улсын Их Хурал дээр авто тээврийн тухай хуулийн ажлын хэсэг гарсан байна. Энэ ажлын хэсгийн маань тодорхой саналаа Байнгын хороо руу оруулаад Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцээд үндсэндээ ингэж.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: С.Бямбацогт сайд нэмж хариулъя. Дуусгаад хариулчихъя.

С.Бямбацогт: Тэгээд өөрөөр хэлэх юм бол үндсэндээ буруу талдаа рультэй машиныг хэрхэн яаж зохицуулах вэ, шийдвэрлэх вэ гэдэг асуудал бол Улсын Их Хурлын ажил болчихоод байгаа.

Тодорхой хугацаанд тийм ээ, 2028 оноос ч гэдэг юм уу. Тэр хүртэл буруу талдаа рультэй машиныг хориглоно шүү гээд тодорхой хугацаанд хязгаарлах, багасгах ийм замаар үндсэндээ Монгол Улсад явж байгаа буруу талдаа рультэй машиныг зохицуулах иймэрхүү л асуудлууд яригдаж байгаа.

Яг өнөөдөр гэнэтхэн зогсоогоод, хаагаад явуулахгүй гэх юм бол тодорхой хөрөнгө зараад авчихсан байдаг, гаднаас шууд оруулж ирэхгүй гэх юм бол иргэдэд чирэгдэл учрах гээд байдаг.

Тэгэхээр энэ дээр ажлын хэсэг маань энэ хаврын чуулганаар л оруулж ирнэ гэж байгаа. Тодорхой шийдэл орж ирэх байх.

Тэр яг өөрийн чинь ярьж байгаа машины түүхтэй холбоотой юм бол бид цаашдаа байнга шаардлага тавина. Үүнийг улам боловсронгуй болгоод, машины түүхийг Монгол Улсад, гадаадад эвдэрсэн үү, гэмтсэн үү, ямархуу засвар, үйлчилгээ хийлгэсэн, ямар хүн эзэмшиж байсан бүх түүхийг нааш нь оруулж ирэх тал дээр илүү дэвшилттэй ажлууд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа.

Б.Энх-Амгалан: Баярлалаа Нямаагийн Энхболд гишүүн асуултаа асууя. Н.Энхболд гишүүний микрофоныг өгье.

Н.Энхболд: Энэ конвенцыг ашиглаад. Одоо жишээ нь Солонгостой юм яриад энэ Монголд оруулж ирж байгаа машинууд, Солонгосоос наашаа явж байгаа машинууд тэр Нэгдсэн Үндэстний Байгууллагын зүгээс тавьдаг шаардлагуудыг биелүүлэхгүй байна шүү дээ гэж үзээд Солонгосын талаас тийм машиныг нааш нь явуулахгүй байх арга

хэмжээ авхуулах боломж бий юу? Энэ конвенцыг ашиглаад.

Тэгэхгүй бол саяын бэрхшээлүүд яг гарч байгаа байхгүй юу. Хүн хямдхан машин авна гээд тэндээ ашиглаж болохгүй болчихсон тийм машинуудыг авчраад энд зараад байдаг. Манайхан хямдыг нь бодоод авчраад засаад юу яагаад байдаг. Гэтэл тэр нь нөгөө конвенцод туссан.

Нэгэнт л Нэгдсэн Үндэстний Байгууллагын нийтлэг тэр конвенцод туссан ийм машиныг ашиглаж болохгүй шүү гээд, үйлдвэрлэж болохгүй шүү гээд заачихсан юм бол тэр гаргаж байгаа улс нь ч гэсэн тэр конвенцынхаа дагуу хариу өгөөд зогсоогоод байх ийм боломж бий юу? Ашиглаж болох уу? Бид нар.

Тэгвэл маш хэрэгтэй байгаа юм. Одоо бидний ярьж байгаа олон түвэгтэй асуудлууд тал нь тэнд шийдэгдчих байхгүй юу. Үүнийг л би сонирхоод байгаа юм. Энэ конвенцтой холбогдуулаад.

Б.Энх-Амгалан: Хэн хариулах вэ? 4 номер. Төрийн нарийн бичгийн дарга хариулъя. С.Батболд дарга хариулъя.

С.Батболд: Н.Энхболд гишүүний асуултад хариулъя.

Энэ бол боломжтой. Бид энэ конвенцод нэгдэн орсноор ер нь Монгол Улсад цаашдаа машин, сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэвэл ямар байх юм. Мөн тээврийн хэрэгслийн ашиглалтад бид ямар шаардлага тавих юм бэ гэдгийг энэ конвенцод нэгдэн орсноороо бид тодорхой болгож байгаа юм.

Мөн бид 1997 онд Олон улсын худалдааны байгууллагад нэгдэн орсон.

Тэгэхээр бид импортын өмнөх техникийн хяналт гэдэг юмыг бид үүний дараа дараагийн шатаар тавих юм.

Тэр нь юу байх вэ гэхээр Монгол Улс бол импортоор орж ирэх ийм ийм бараа, бүтээгдэхүүнд импортоор орж ирэхээс өмнө хяналт тавьдаг боллоо шүү. Бид ийм машин цаашдаа авна шүү. Үүнээс өөр үзүүлэлттэй юмыг авахгүй шүү гэдэг юмаа бид Нэгдсэн Үндэстний Байгууллагаар дамжуулаад, Нэгдсэн Үндэстний Байгууллага тухайн орнуудад энэ шаардлагуудыг хүргүүлээд, Монгол Улс ийм боллоо шүү гэдэг юмыг тавиад, ингээд дэлхий нийтээр зарлаад явах ийм боломжууд байгаа. Бид яг энэ шатууд руу явж байгаа.

КОЙКА-тай хамтраад энэ жилээс манайд замын хөдөлгөөний аюулгүй байдлын нэг төсөл эхэлж байгаа. Энэ хүрээнд бид Солонгосоос техникийн хяналтын үзлэгийн буюу оношилгооны тоног төхөөрөмж сайжруулна.

Мөн Солонгосоос Монгол руу импортоор орж ирж байгаа машины түүхийг шууд авдаг ийм системүүдийг бид хөгжүүлж байна. Энэ оны 3 сарын сүүлээр КОЙКА-тай гэрээгээ байгуулаад энэ онд энэ төсөл эхлэх юм.

Мөн бид энэ дүрэм журамд оруулсан өөрчлөлтөө Япон, Солонгос зэрэг нийтдээ 19 орноос манайд машин импортоор орж ирж байгаа. Гадаад хэргийн яамаар дамжаад бид ийм болчихсон шүү гэдэг юмаа бол мэдэгдчихсэн байгаа. Тийм. Энэ дээр.

Түрүүний Г.Амартүвшин гишүүний асууж байгаа тэр Америкийн

CARFAX гэдэг мэдээллийн сан манайд бий болоод 6 дахь жилдээ явж байгаа. **Autobox.mn** гэдэг ийм сайт байгаа.

Энд өдөрт 10 гаруй мянган хүн ханддаг юм билээ. Зүгээр тухайн оронд нөгөө ашиглагдаж байсан түүх нь л байхгүй болохоос Монголд ашиг үйлчлэгдэж байсан тэр засвар үйлчилгээ хийж байсан түүхүүд бүгд энд ороод явж байгаа. Ийм систем бий болчихсон байгаа.

Б.Энх-Амгалан: Нямаагийн Энхболд гишүүн тодруулъя.

Н.Энхболд: Бид энэ конвенцтой нэгдээд орчихлоо.

Ийм шаардлага тавьдаг болсон шүү гэдгээ цаад газруудаа мэдэгдчихлээ. Нэгдсэн Үндэстний Байгууллагаар дамжаад байна уу, шууд байна уу. Цаад газрууд чинь энэ дагуу тэндээс гаргахгүй байх ажлыг хийж чадах уу? Тийм үүрэг энэ конвенцоор хүлээж байгаа юу?

Жишээ нь, Монголын тавьж байгаа Н.Энхболд гэдэг хүн очоод тэнд нэг машин авчихъя. Тэрийг нь судлаад үзсэн чинь манай талаас тавьж байгаа шаардлагуудад нийцэхгүй ийм машин, ашиглалтын түүх. Бусад бүх талаараа. Ийм юм нь тэдний талын юман дээр гараад ирлээ. Тэгэнгүүт худалдаж авах гэж байгаа хүнд бид энэ машиныг зарахгүй ээ гэж хэлэх ийм үүрэг, ийм эрх тэнд үүсэх үү? Гол нь тэр л байхгүй юу.

Түүнээс зүгээр яах вэ наашаа мэдээгээ явуулчихдаг. Ийм байна шүү гэсэн мэдээтэйгээ хамт ирдэг. Энд ирсэн хойно нь бид нөгөө муу, ашиглаж болохгүй, агаар бохирдуулдаг. Тийм ээ. Энэ машиныг нэгэнт ороод ирчихвэл яаж

ч чадахгүй л болно шүү дээ. Хамгийн гол нь цаад.../минут дуусав/

Б.Энх-Амгалан: Тодруулгад Төрийн нарийн бичгийн дарга хариулъя. 4 номерын микрофон.

С.Батболд: Н.Энхболд гишүүний асуултад хариулъя.

Энэ конвенцод нэгдэн орсноор бүх нэгдэн орсон орнууд яг саяын таны асууж байгаа асуултад яг ийм үүрэгтэй байж байгаа. Бид үүнийгээ бас шаардах эрхтэй болж байгаа.

Өмнө нь энэ асуудлын гадна байгаад байсан бол бид энэ конвенцод нэгдэн орсноороо Монгол Улсынхаа эрх ашгийг хамгаалаад бид саналаа хэлдэг. Ялангуяа жишээ нь үйлдвэрлэгчийн гологдол гараад энд тэндээс машинууд татдаг.

Бид дилер, дистрибьютерээр дамжуулж аваагүй хуучин нойтон машинууд Монголд ашиглаад явж байсан. Одоо бид энэ талаараа энэ олон улсын хэмжээнд нөгөөдүүлээсээ шаардах ийм эрхтэй. Тэд ч бас ийм үүрэг хүлээж байгаа.

Б.Энх-Амгалан: С.Батболд даргад баярлалаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. /алх цохив/

Одоо хуулийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү. Алга байна. Гишүүд үг хэлж санал гаргаж дууслаа. /алх цохив/

Одоо санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй.

Женев хотноо 1958 онд батлагдсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын уялдуулан зохицуулсан техникийн дүрмийг хэрэглэх болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

10 гишүүн санал хураалтад оролцож, 7 гишүүн дэмжиж, 70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин танилцуулья.

Гишүүд, ажлын хэсэгт баярлалаа. Дараагийн асуудалдаа орёе.

Хоёр.Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг зөвшилцөх /Засгийн газар 2023.01.16-ны өдөр ирүүлсэн/

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенц зөвшилцөх тухай асуудлыг хэлэлцье.

оны үйл ажиллагааны хөтөлбөрт олон улсад өрсөлдөх чадвартай боловсролыг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилтыг тус тус дэвшүүлсэн.

Асуудлыг Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт танилцуулна. С.Бямбацогт гишүүний микрофоныг өгье. Ажлын хэсгийг оруулж суулгаарай.

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхэд дэлхийн улсуудтай боловсрол, сургалт, эрдмийн зэрэг цолыг харилцан хүлээн зөвшөөрөх явдал чухал үүрэг гүйцэтгэх юм.

С.Бямбацогт: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Дээд боловсролын сургалт болон эрдмийн зэрэг, цолыг харилцан хүлээн зөвшөөрөх үйл ажиллагааг зохицуулах хэм хэмжээг тодорхойлсон баримт бичиг батлах ажил 1975 оны 6 дугаар сард Латин Америк болон Карибд дээд боловсролын сургалт, диплом, эрдмийн зэрэг, цолыг хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн конвенцыг баталснаар эхэлж үүнээс хойш дэлхийн бүх бүс нутгийг хамруулан ижил төрлийн 11 конвенцыг баталсан байдаг.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор “**Алсын хараа-2050**” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдаж Хүний хөгжил төвтэй хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж байна.

Энэхүү урт хугацааны бодлогын хэрэгжилтийг хангах үүднээс Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл болон 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024

Монгол Улс ЮНЕСКО-гийн Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай 1960 оны конвенцод 1964 онд нэгдсэн, Техник болон мэргэжлийн

боловсролын тухай 1989 оны конвенцод 1991 онд нэгдсэн, Ази, Номхон далайн орнуудын дээд боловсролын сургалт, диплом, эрдмийн зэрэг цолыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн Бангкогийн 1983 оны конвенцод 1991 онд нэгдэн орсон.

Ази, Номхон далайн орнуудын дээд боловсролын эрдмийн зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх тухай бүс нутгийн 2011 оны Токиогийн конвенц 2018 онд тус тус нэгдэн орж, Засгийн газрын 2018 оны 399 дүгээр тогтоолоор Дээд боловсролын эрдмийн зэрэг хүлээн зөвшөөрөх тухай Ази, Номхон далайн бүс нутгийн конвенцыг баталсан.

2019 оны 11 дүгээр сард ЮНЕСКО-гийн Ерөнхий бага хурлын 40 дүгээр чуулганаар Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхийн дахины конвенцыг баталсан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас дээд боловс боловсролын салбарт хамаарсан анхны дэлхийн хэмжээний гэрээ болсон юм.

Энэхүү конвенцод нэгдэн орсон улс орнуудын их, дээд сургуулиудын боловсрол, сургалтын үр дүн, зэрэг цолыг ил тод, шударгаар хүлээн зөвшөөрөх, суралцагчдад бусад орны их дээд сургуулиудад үргэлжлүүлэн суралцах, хөдөлмөр эрхлэх, зайн хэлбэрийн суралцаж эзэмшсэн мэргэжлээ хүлээн зөвшөөрөх боломжийг олгодог.

Иймд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дээд боловсролын тогтолцоог хөгжүүлэхэд энэхүү конвенцод нэгдэн орох нь зайлшгүй шаардлага үүслээ.

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай Дэлхий дахины конвенцыг соёрхон баталснаар Монгол Улс олон улсын хамтын нийгэмээс авч хэрэгжүүлж буй санал, санаачилга, дэлхийн улс орнуудтай дээд боловсролын салбарт өргөнөөр өрнүүлэх харилцаа, хамтын ажиллагаанд идэвхтэй оролцох, олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монголын дээд боловсролыг олон улсад хүлээн зөвшөөрүүлэхэд хувь нэмрээ оруулах болно.

Конвенцод нэгдэх нь ЮНЕСКО-гийн гишүүн орнуудад нээлттэй байдаг бөгөөд 2023 оны 01 дүгээр сарын байдлаар 21 улсад нэгдэн орсон бөгөөд 2023 оны 03 дугаар сарын 05-нд дэлхийн конвенц хүчин төгөлдөр болоод байна.

ЮНЕСКО-гоос дэлхий дахины боловсролын тухай анхны гэрээ бодитой болсноор боловсролын шинэ эрин эхэлж, дээд боловсролын уян хатан байдал, хүртээмжид хандах хандлагад хувьсгал гарна гэж үзэж байна.

Учир нь конвенц нь дээд боловсролын хүртээмжийг ардчилах, өрсөлдөөнөөс илүү хамтын ажиллагаа, нэгдмэл байдлаас илүү олон талт байдал, уламжлалт аргаар суралцахаас илүү уян хатан арга барилыг дэмжиж, чанартай боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхэд тус дөхөм болно.

Конвенц хүчин төгөлдөр болсон нь дэлхийн дээд боловсролыг өөрчлөх эхлэл болж, чанартай дээд боловсролын талаарх Тогтвортой хөгжлийн зорилтын 4. 3-д хүрэхэд нэг алхам ойртуулж байна.

Энэ нь бүгдэд илүү тэгш, хүртээмжтэй, тогтвортой ирээдүйг бий болгох хэрэгсэл юм.

Дээд боловсролын тогтолцоо, эрдмийн зэрэг, цол, чанарын баталгаажилтын талаарх үнэн зөв мэдээллийг ил тод, хүртээмжтэй байлгах үүднээс Боловсролын мэдээллийг нэгтгэх, түгээх чиг үүргийг Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл хариуцан ажиллах бөгөөд энэ нь одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Боловсролын тухай хууль тогтоомжийн хүрээнд зохицуулагдана.

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг соёрхон батлахыг дэмжихийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Б.Энх-Амгалан: С.Бямбацогт сайд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд Сандагийн Бямбацогт асуудлыг танилцуулж байна.

П.Оюунаа Боловсрол, шинжлэх ухааны яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ж.Нарантуяа тус яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч, Ж.Ариунболд Боловсролын зээлийн сангийн захирал, Д.Баяр судлаач.

Ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна.

Хуралдаан 30 минут үргэлжилж, 13 цаг 28 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Төслийн талаарх танилцуулгатай холбогдуулан асуулт асуух гишүүд байвал нэрээ өгнө үү. Алга байна. Гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. /алх цохив/

Төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд байвал нэрээ өгнө үү. Алга байна. Гишүүд үг хэлж санал гаргаж дууслаа. /алх цохив/

Одоо санал хураалт явуулна. Гишүүд бэлдээрэй.

Дээд боловсролд хамаарах эрдмийн зэргийг хүлээн зөвшөөрөх тухай дэлхий дахины конвенцыг зөвшилцөх тухай асуудлыг зөвшөөрч гарын үсэг зурах эрхийг Засгийн газарт олгоё гэсэн томьёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Санал хураалтад 11 гишүүн оролцож, 6 гишүүн дэмжиж, 54.5 хувиар уг санал дэмжигдлээ.

Уг асуудлыг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны хуралдааны тэмдэглэл болон санал, дүгнэлтийг Засгийн газарт хүргүүлнэ.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдааныг хаасныг мэдэгдье. Гишүүд ажлын хэсэгт баярлалаа. Хуралдаан өндөрлөлөө. /алх цохив/

Ц.АЛТАН-ОД